



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 439

Улаанбаатар хот

Өмчлөх эрхийг шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 29 дүгээр зүйлийн 1, 43 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 219 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 229 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдааны тэмдэглэл, Монгол Улсын иргэн Ядамсүрэнгийн Энхцэцэгтэй байгуулсан "Худалдах, худалдан авах гэрээ"-ний 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 2-р багийн нутаг дэвсгэрт байрлалтай, Булаг тооцооны төвийн хуучин барилга байгууламжийг худалдах 2018 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн нээлттэй дуудлагын худалдааны ялагч Ядамсүрэнгийн Энхцэцэг нь нийт үнэ 133,450,000.00 (нэг зуун гучин гурван сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийг хууль болон гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж, гэрээний 3.5, 4.2.2-т заасан үүргээ биелүүлсэн тул иргэн Я.Энхцэцэгт дээрх барилга байгууламжийн өмчлөх эрхийг шилжүүлсүгэй.

2.Иргэн Я.Энхцэцэгт өмчлөх эрхийн гэрчилгээ олгохыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3.Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 2-р багийн нутаг дэвсгэрт байрлалтай Булаг тооцооны төвийн хуучин барилга байгууламжид ногдох эзэмшил газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шинэ өмчлөгчид олгохыг Архангай аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасанд зөвлөсүгэй.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002309